

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ  
ТОГТООЛ

55  
БНМАУ-ЫН ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХ  
ЯАМ, САНГИЙН ЯАМНЫ САЙДЫН  
ТУШААЛ

1986 оны 10- дугаар  
сарын 20-ны өдөр

Дугаар... 211/147/260

Улаанбаатар  
хот

АХГЗ-ноос 1989 оны 16.1-р тогтоолд

Нягтлан бодох бүртгэл, аж ахуйг  
төвлөрүүлэх арга хэмжээний тухай

Төвлөрсөн нягтлан бодох анги байгуулах тухай БНМАУ-ын Сайд  
нарын Зөвлөлийн 1979 оны 385 дугаар тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Улаанбаатар хотын Найрамдал, Ажилчин, Сүхбаатар, Октябрийн  
районд эмнэлэг, урьдчилан сэргийлэх байгууллага, яслийн төвлөрсөн  
нягтлан бодох ангитай нэгдсэн аж ахуйг, зохих бэлтгэлийг сайн хан-  
гасны үндсэн дээр 1986-1987 онд байгуулж ажиллуулахыг Улаанбаатар  
хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны санхүүгийн хэлтэс /н.Эрдэмбат/,  
Эрүүлийг хамгаалах газар /н.Бямбаа/-т даалгасугай.

2. Эмнэлэг, яслийн нэгдсэн аж ахуйг орон байраар хангахыг  
районуудын АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга нарт даалгасугай.

3. Улаанбаатар хотын эмнэлэг, яслийн нэгдсэн аж ахуйд шаардаг-  
дах хүнсний зүйл, барилгын засварын материал, бусад эд хогшил, хөрөн-  
гийг жил бүрийн төлөвлөгөөнд тусгаж хуваарилж байхыг хотын төлөвлө-  
гөөний комисс /н.Ганбаатар/, Их барилгын хэлтэс /н.Нэргүй/, Эрүүлийг  
хамгаалах газар /н.Бямбаа/-т даалгасугай.

4. Районуудын эмнэлэг, яслийн нэгдсэн аж ахуйн хэрэгцээний мах,  
сүү, масло, талх зэрэг хүнсний бүтээгдэхүүн, үйлчилгээний авто машиныг  
тэргүүн ээлжинд аж ахуйн гэрээний дагуу тасралтгүй хангаж байхыг  
Хотын Худалдаа удирдах газар /н.Шагдар/, Сүүний үйлдвэр /н.Дамдин-  
сүрэн/, Тээврийг удирдах газар /н.Сэрээтэр / нарт даалгасугай.

5. Райодын эмнэлэг, яслийн төвлөрсөн ня-бо ангийг ээлж дараатай-  
гаар тооцоолон бодох машинаар хангаж, бүртгэл тооцооны ажлыг механик-

жуулах арга хэмжээ авахыг Улаанбаатар хотын АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны Санхүүгийн хэлтэс /н.Эрдэмбат/, Сангийн яамны нягтлан бодох бүртгэлийг механикжуулах төв /н.Цэдэндамба/-т даалгасугай.

6. Хотын эмнэлэг, яслиудын санхүү, аж ахуй, бүртгэл тооцооны ажлыг төвлөрүүлж, нэгдсэн төсөв, тайлан баланс гаргах болсонтой холбогдуулан нийт орон тоо, цалингийн фонддоо багтааж, хотын эрүүлийг хамгаалах газарт зааварлагч нягтлан бодогчийн орон тоо бий болгохыг Эрүүлийг хамгаалах газар /н.Бямбаа/-т зөвшөөрсүгэй.



УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ  
ДАРГА  
С.МӨНХЖАРГАЛ



БНМАУ-ЫН ЭРҮҮЛИЙГ  
ХАМГААЛАХ ЯАМНЫ  
САЙД  
Ч.ЦЭРЭННАДМИД



БНМАУ-ЫН САНГИЙН  
ЯАМНЫ САЙД  
Д.МӨЛӨМЖАМЦ